



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 5/984

Улаанбаатар хот

Х.Ариунааг ажлаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7, 271¹.1.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Хээшигийн Ариунааг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Х.Ариунаад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гараад олгох нэг удаагийн буцалтгүй тусlamж болох 29 751 100 /хорин есөн сая долоон зуун тавин нэгэн мянга нэг зуун/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Х.Ариунаагийн гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авч, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг “Чингис хаан” олон улсын нисэх буудал дахь гаалийн газар /Г.Баасандорж/-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захирагааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

• 1439501 3126